

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

*“Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”-д
хийсэн нийцлийн аудитын тайлан*



ЗГТС-ийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна

Улаанбаатар хот
2016 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын Нийцлийн аудитын газар

НАГ-ын дарга
Б.Алтанзул

Менежер
Х.Болдбаатар

Ахлах аудитор
Ш.Энхтайван

Шинжээч
М.Туул
Ц.Цэрэннамжил
Б.Баярмаа

2016 оны 10 дугаар сар
уг тайланг ҮАГ-ын веб
сайт-аас үзнэ үү.
www.audit.gov.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
261729 дугаарын утас,
260949 дугаарын
факсаар
харилцана уу.

Хаяг:
Үндэсний аудитын газар
210642 Чингэлтэй
дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр
байр,
Бага тойруу-3,
Улаанбаатар 15160
Монгол улс

Товчилсон үгийн жагсаалт	2-3
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	4
Аудитын зорилт.....	4
Аудитын хамрах хүрээ.....	4
Арга зүй.....	4
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд.....	4
Аудитыг гүйцэтгэх явцад гарсан хүндрэл бэрхшээл.....	5
Ерөнхий мэдээлэл.....	6-7
БҮЛЭГ.1 ЗГТС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРЭН БҮРДЭЭГҮЙ БАЙНА	
1.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	8-9
1.2 Байгаль хамгаалах сан.....	9-10
1.3 Зэвсэгт хүчний хөгжлийн сан.....	11
1.4 Сургалтын төрийн сан.....	11-12
БҮЛЭГ.2 САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭР БҮРЭЭР БҮРДҮҮЛЭХГҮЙ БАЙНА	
2.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	13-14
2.2 Байгаль хамгаалах сан.....	14-16
2.3 Зэвсэгт хүчний хөгжлийн сан.....	16-17
2.4 Сургалтын төрийн сан.....	17
БҮЛЭГ.3 САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА	
3.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	18-19
3.2 Байгаль хамгаалах сан.....	19-22
3.3 Зэвсэгт хүчний хөгжлийн сан.....	22-25
3.4 Сургалтын төрийн сан.....	25-27
БҮЛЭГ.4 ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	
4.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	28-29
4.2 Байгаль хамгаалах сан.....	29-30
4.3 Зэвсэгт хүчний хөгжлийн сан.....	30
4.4 Сургалтын төрийн сан.....	31
Дүгнэлт.....	32
Зөвлөмж.....	33-34
Хавсралтууд.....	35
Холбогдох байгууллагын санал.....	
Тушаал.....	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АШУИС	Анагаахын шинжлэх ухааны их сургууль
БХС	Байгаль хамгаалах сан
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам /хуучнаар/
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХАҮН ТӨҮГ	Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл Төрийн өмчит үйлдвэрийн газар
БХЯ	Батлан хамгаалах яам
БЗТ	Барилга захиалагчийн товчоо
БЗС	Боловсролын зээлийн сан
БЗА	Барилга захиалагчийн алба
ДБСБ	Дээд боловсролын сургалтын байгууллага
ДШИС	Дэлхийн шилдэг их сургууль
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗГТСТХ	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
ЗХХС	Зэвсэгт хүчний хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБСДС	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
МБСЗГ	Мэргэжлийн боловсрол, сургалтыг зохицуулах газар
МИС	Механик, инженерийн сургууль
МУ	Монгол Улс
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮББОХ	Нэгдсэн үндэстний байгууллагын байгаль орчны хөтөлбөр
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
СБТХ	Стратеги бодлого төлөвлөлтийн хэлтэс
СТС	Сургалтын төрийн сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УГТХ	Ургамал газар тариалангийн хүрээлэн
УИХ	Улсын Их Хурал
УУЭХ	Уул уурхай эрчим хүч

ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮТДС	Үйлдвэр технологийн дээд сургууль
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХАХНХС	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд
ХЗЯ	Хууль зүйн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХТШ	Хязгаарлагдмал тендер шалгаруулалт
ХШҮДАГ	Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар
ХЯ	Хөдөлмөрийн яам
ШУТИС	Шинжлэх ухаан, технологийн их сургууль

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 1 дүгээр тогтоол, ҮАГ-аас Монгол Улсын Ерөнхий аудитор 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар тодорхойлогдсон Байгаль хамгаалах сан, Зэвсэгт хүчний хөгжлийн сан, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан, Сургалтын төрийн сангийн үйл ажиллагаа, сангийн хөрөнгөөр санхүүжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд чиглэгдсэн.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэв. Үүнд:

- Сангийн хууль, эрх зүйн зохицуулалт оновчтой эсэх;
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх;
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаж байгаа эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад БОАЖЯ, БХЯ, ХНХЯ, БСШУЯ, Байгаль хамгаалах сан, Зэвсэгт хүчний хөгжлийн сан, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан, Сургалтын төрийн сан болон холбогдох харьяа байгууллага, төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд, орон нутгийн байгаль хамгаалах сангууд хамрагдлаа.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 400, 4000 болон Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, асуулга лавлагаа тайлбар, мэдээ гаргуулах, нотлох баримтыг баталгаажуулах, санхүүгийн болон хяналтын тайланг судлах зэрэг аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийж зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн шалган баталгаажуулав.

Аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль тогтоомж, заавар журмыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Гадаад зээл, тусламжийг зохицуулах тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, түүнд хяналт тавих журам;
- Байгаль хамгаалах сангийн дүрэм;
- Байгаль хамгаалах сангийн зохион байгуулалт;
- Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам;
- Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам;
- Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам;
- Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Аудитыг гүйцэтгэх явцад гарсан хүндрэл бэрхшээл

МУ-ын ЗГ-ын бүтцийн тухай хуулийг УИХ 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдөр баталснаар ХЯ шинээр зохион байгуулагдаж ХНХЯ болсонтой холбоотойгоор МБСДС-ийн зарим ажлыг хариуцах албан тушаалтан томилогдоогүй, тайлбар, баримт материал, мэдээлэл өгөх ажилтан байхгүй зэрэг бэрхшээл аудитын явцад гарсан болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

УИХ-аас 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдөр баталсан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг үндэслэн Засгийн газрын 2009 оны 257 дугаар тогтоолоор Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан (МБСДС) байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 6¹ дугаар зүйлийн 6^{1.1}¹, 21 дүгээр зүйлийн 21.1², 6 дугаар зүйлийн 6.3.5³-д заасны дагуу Хөдөлмөрийн яам уг сангийн үйл ажиллагааг явуулж, Үндэсний зөвлөл хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сангаас Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн өмчит 79⁴ МБСБ-ын нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, амьжиргааны тэтгэлгийн санхүүжилтийг 2015 онд 35 МБСБ-ын 11,854 суралцагчийн хувьсах зардалд 4,488.8 сая төгрөг, 78 МБСБ-ын 34,817 суралцагчийн тэтгэлэгт 11,251.3 сая төгрөг, мэдээллийн сан бүрдүүлэх програм хангамжийн зардалд 200.0 сая төгрөг, 2016 онд 37 МБСБ-ын 10,898 суралцагчийн хувьсах зардалд 4,696.6 сая төгрөг, 79 МБСБ-ын 33,560 суралцагчийн тэтгэлэгт 10,149.3 сая төгрөг, мэдээллийн сан бүрдүүлэх програм хангамжийн зардалд 67.5 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Байгаль хамгаалах сан

Байгаль хамгаалах сан нь Засгийн газрын 1998 оны 188 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдаж 2012 оны 189 дүгээр тогтоолоор сангийн бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсны дагуу 5 хүний орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус сангийн санхүүжилт 2015 онд 2,678.2 сая төгрөгөөр батлагдаж, төсвийн тодотголоор 2,086.6 сая төгрөг болж буурсан бөгөөд гүйцэтгэлээр 1,776.4 сая төгрөгийг зарцуулсан бол 2016 онд 1,900.0 сая төгрөг батлагдаж 8 дугаар сарын 31-ний байдлаар 889.9 сая төгрөгийг сангийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар, орон нутгийн байгаль хамгаалах санг Төсвийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2015 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 07 дугаар тушаалын дагуу 10 аймаг “Орон нутгийн байгаль хамгаалах сан”-г татан буулгасан боловч Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өмнөговь, Увс, Сэлэнгэ,

¹ Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо нь зөвлөл, мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үнэлгээ, мэдээллийн болон бүсийн арга зүйн төв, сургалтын байгууллагаас бүрдэнэ.

² Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

³ мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

⁴ Гадаадад байршилтай, ХСИС-аас санхүүждэг 2 сургууль хасагдсанаар

Сүхбаатар, Хэнтий аймгууд “Орон нутгийн байгаль хамгаалах сан” нэрээр үйл ажиллагааг нь үргэлжлүүлэн явуулж байна.

Зэвсэгт хүчний хөгжлийн сан

МУ-ын Ерөнхийлөгчийн 2006 оны 304 дүгээр зарлигаар баталсан “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-т Зэвсэгт хүчний хөгжлийн сан байгуулах зорилт тусгагдсанаар тус сангийн эрх зүйн орчны эхлэл тавигдсан байна.

2009 онд УИХ-аас Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Зэвсэгт хүчний хөгжлийн санг нэмсний дагуу Батлан хамгаалахын сайдын 2009 оны 290 дүгээр тушаалаар⁵ сангийн журам, удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, сангийн үйл ажиллагааг эхлүүлсэн байна.

Тус санд 2015 онд 49,498.7 сая төгрөгийн орлого төвлөрснөөс жилийн эцэст 30,467.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, 19,031.6 сая төгрөгийн он дамжсан үлдэгдэл, 2016 онд орлогын төлөвлөгөөг 47,172.2 сая төгрөгөөр баталснаас, 9 дүгээр сарын 30-ны байдлаар 35,836.9 сая төгрөгийн орлого төвлөрч, 23,845.8 сая төгрөгийн зарлагын гүйцэтгэлтэй байна.

Сургалтын төрийн сан

Сургалтын төрийн сан нь 1993 онд байгуулагдаж Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох үйлчилгээг үзүүлж иржээ.

Тус сан нь 2011-2015 онд дотоод, гадаадын ДБСБ-д суралцагчдын санхүүжилтэд 641.3 тэрбум төгрөгийг төсөвлөснөөс 942.8 мянган суралцагчдад 573.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосны 91.2 хувь буюу 523.3 тэрбум төгрөгийг тэтгэлэг тусламжид, 8.8 хувь буюу 50.4 тэрбум төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл байна.

Сургалтын төрийн сан нь УИХ-ын 2016 оны “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль болон Боловсролын зээлийн сан байгуулах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор “Боловсролын зээлийн сан” болж өөрчлөн зохион байгуулагдсан байна.

⁵ Батлан хамгаалахын сайдын 2009 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.1-д Зэвсэгт хүчний хөгжлийн сан нь “Зэвсэгт хүчнийг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх, зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах, цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох чадавхийг нэмэгдүүлэх, цэргийн алба хаагчдын нийгмийн болон салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг нөөц бололцоондоо тулгуурлан бий болгох зорилготой

БҮЛЭГ.1 ЗГТС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН БҮРЭН БҮРДЭЭГҮЙ БАЙНА

1.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, түүнд хяналт тавих журам, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам, Зардлын дундаж норматив батлах тухай ЗГ-ын 2012 оны 94 дүгээр тогтоол, Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлийн дүрэм, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам, МБСГ-ын даргын баталсан “Санхүүжих дундаж хүүхэд тооцох аргачлал” зэрэг эрх зүйн актаар зохицуулж байна.

Хууль болон журмын зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2⁶-т заасны дагуу Засгийн газрын 2011 оны 117 дугаар тогтоолоор баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-аар сангийн үйл ажиллагааг зохицуулж байгаа боловч дээрх хууль болон журмын зарим заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- Хөдөлмөрийн яам нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг өөрийн өртөгт үндэслэн тогтоож, ЗГ-аар батлуулаагүй нь Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3⁷, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2⁸ дахь заалтыг;
- Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад суралцагчдад тэтгэлгийг хичээлийн ирцийн хувиар тооцоолон хувилж олгосон нь тэтгэлэг олгох журмын 2.2.2⁹ дахь заалтыг;
- МБСДС-д орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг ИТХ-аас тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батлуулаагүй нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2¹⁰ дахь заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Мөн Баянхонгор аймгийн Өлзийт ХАА-н МСҮТ-д 2014-2015 оны хичээлийн жилд 261, 2015-2016 оны хичээлийн жилд 263 суралцагч ЕБС-д давхар суралцан тэтгэлэг, хувьсах зардал авч байгаа нь төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байлгахаар зохицуулах хууль эрх зүйн зохицуулалт тодорхойгүйгээс шалтгаалж байна.

Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй журмын зарим заалтыг хуульд нийцүүлэх шаардлагатай байна

⁶ “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална”

⁷ “... мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, ... нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно”

⁸ Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг

⁹ Хүндэтгэн үзэх шалгаантайгаас (эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдал гэх мэт) бусад тохиолдолд онолын болон дадлагын сургалтад 75 хувиас доошгүй ирцтэй оролцсон байх

¹⁰ “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн ИТХ тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална”

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын зарим заалтуудыг бусад хуулийн шинэчлэл, өөрчлөлттэй нийцүүлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Сангийн журмын 2.9 “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр Сангийн хөрөнгийг арилжааны банкны дансанд байршуулж болно” гэсэн хүчингүй болсон хуулийн заалтыг Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11¹¹ дэх заалттай нийцүүлэх;
- Сангийн журмын 2.4.2 дахь заалт “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага ” гэж заасныг 8 дугаар зүйлд нийцүүлэх;

Мөн 2016 онд Мэргэжлийн боловсролын тухай хуульд орсон өөрчлөлттэй холбогдуулан хуулийн 13 дугаар зүйлийн 13.3¹²-т заасан МБСБ орлого олох зарцуулах, тайлагнах тухай журмыг боловсруулан Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлуулаагүй байна.

1.2 Байгаль хамгаалах сан

Орон нутгийн БХС-ийн эрх зүйн орчин бүрдээгүй байна

Байгаль хамгаалах сан нь ЗГТСТ хууль, МУ-ын Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолоор баталсан “*Байгаль хамгаалах сангийн зохион байгуулалт*” болон БХС-ийн Удирдах зөвлөлийн 2013 оны 3 дугаар хурлын шийдвэрээр баталсан “*Байгаль хамгаалах сангийн дүрэм*”-ийн дагуу үйл ажиллагаа явуулж байна.

ЗГТСТ хуульд 2015 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр санг ажлын албагүй байхаар хуульчилсан байхад ЗГ-ын 2012 оны 189 дүгээр тогтоолын дагуу 5 хүний орон тоотой ажлын алба ажиллуулж байгаа нь энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.3¹³ дахь заалтыг зөрчсөн байна.

Сангийн сайдын 2015 оны “*Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай*” 07 дугаар тушаалын дагуу аймаг, нийслэлийн засаг дарга нарт 4-3/760 дугаар албан бичгээр хүргүүлсэн зөвлөмжийг¹⁴ 11 аймгийн ЗД хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

д.д	Аймаг	Орон нутгийн байгаль хамгаалах сан
1	Баян-Өлгий	Аймгийн БХС нь үйл ажиллагаа явуулж, сумдад БХС байхгүй байна.
2	Говьсүмбэр	Аймгийн БХС нь татан буугдаж БОАЖГ-т нэгтгэсэн боловч сумын БХС үйл ажиллагаа явуулж байна.
3	Дорноговь	Аймгийн БХС болон 7 суманд БХС-ийн үйл ажиллагаа явж байна.
4	Дорнод	Аймгийн БХС болон 14 суманд БХС-ийн үйл ажиллагаа явж байна.

¹¹ банкинд данс нээх зөвшөөрлийг төсвийн байгууллагад олгох;

¹² Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

¹³ ... энэ хуулийн 6.4.6, 6.4.10-т зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулж, санхүүжүүлэхийг хориглоно.

¹⁴ “... орон нутгийн тусгай сангуудыг татан буулгах ажлыг зохион байгуулах, татан буугдсан сангуудаас хэрэгжүүлж байсан үйл ажиллагааг хэвээр үргэлжлүүлэх шаардлагатай бол Засаг дарга, эсвэл ЗДТГ-ын төсөвт тусгай хөтөлбөр, зориулалтаар орлого, зарлагыг тусган төлөвлөж, тайлагнах ...”

5	Дундговь	Аймгийн БХС нь татан буугдаж БОАЖГ-т нэгтгэсэн боловч 15 сумын БХС үйл ажиллагаа явуулж байна.
6	Өмнөговь	Аймгийн БХС болон 15 суманд БХС-ийн үйл ажиллагаа явж байна.
7	Сүхбаатар	Аймгийн БХС болон 9 суманд БХС-ийн үйл ажиллагаа явж байна.
8	Завхан	Аймгийн БХС нь татан буугдаж БОАЖГ-т нэгтгэгдэж зөвхөн Дөрвөлжин сумын БХС үйл ажиллагаа явуулж байна.
9	Хэнтий	Аймгийн БХС нь татан буугдаж БОАЖГ-т нэгдсэн боловч 16 сумын БХС үйл ажиллагаа явуулж байна.
10	Увс	Аймгийн БХС нь татан буугдаж БОАЖГ-т нэгтгэсэн боловч 7 сумын БХС үйл ажиллагаа явуулж байна.
11	Сэлэнгэ	Аймгийн БХС болон 5 суманд БХС-ийн үйл ажиллагаа явж байна.

Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4¹⁵ дэх заалтыг үндэслэн Увс, Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь аймгууд ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаараа “*Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах журам*” баталж орон нутгийн БХС-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хангасан байхад Сангийн сайдын 2015 оны 4-3/760 дугаар албан бичгээр хүргүүлсэн байгаль хамгаалах санг татан буулгах зөвлөмжийг Баян-Өлгий, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Сүхбаатар, Завхан, Хэнтий аймгууд хэрэгжүүлэлгүй ЗГТСТ хуулиар зохицуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн дээрх заалтыг баримтлаагүй байна.

Орон нутгийн БХС-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хангах үүднээс Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 44 дүгээр тогтоолоор баталсан “*Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах журам*”-ын 3.1-д “*Санд орох хөрөнгийг аймаг, сумдын арилжааны банкны салбаруудад тусгай дансанд төвлөрүүлнэ*” гэж заасан нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3¹⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

Байгаль хамгаалах сангийн Удирдах зөвлөл баталсан дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулахгүй байна

Сангийн Удирдах зөвлөл нь “*Байгаль хамгаалах сангийн зохион байгуулалт*”-ын 2.4¹⁷, “*Байгаль хамгаалах сангийн дүрэм*”-ийн 3.1¹⁸-д заасныг хэрэгжүүлэлгүй 2015 оны 2 дугаар сараас хойш хуралдаагүй бөгөөд сангийн 2016 оны үйл ажиллагааны төсөв, арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэж батлаагүй нь “*Байгаль хамгаалах сангийн зохион байгуулалт*”-ын 2.7.1¹⁹, 2.7.2²⁰-т заасан чиг үүргийг биелүүлээгүй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн заалт ЗГТСТ хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байна

¹⁵ Орон нутгийн тусгай санг байгуулах, түүний үйл ажиллагааны зарчим, хэрэгжүүлэх чиг үүрэг, уг сангийн орлого, түүний зарцуулалтын талаарх харилцааг энэ хуулиар зохицуулна

¹⁶ Санхүү, төсвийн асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ

¹⁷ Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана

¹⁸ Сангийн зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд сард 1-ээс доошгүй удаа хуралдана...

¹⁹ Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах

²⁰ Сангийн тухайн жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг батлах, сангийн хөрөнгийг өсгөх талаар гарсан санал, санаачлагыг дэмжих, сангийн үндсэн хөрөнгө, урсгал зардлыг батлах

УИХ-аас 2012 онд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль баталснаар ЗГТСТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2²¹-д заасан сангийн эх үүсвэр хүчингүй болсон боловч энэ хуульд холбогдох өөрчлөлт оруулаагүй байна.

1.3 Зэвсэгт хүчний хөгжлийн сан

2015 онд ЗГТСТ хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт сангийн зорилготой нийцэхгүй байна

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд 2010 онд 25¹ дугаар зүйлийн 25^{1.2.8}²², 2015 онд 25¹ дугаар зүйлийн 25^{1.2.9}²³ дахь заалтууд нэмэгдэж Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийг нийт 9 заалтын хүрээнд зарцуулахаар хуульчилсан байхад Сангийн журамд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Харин Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25¹ дугаар зүйлийн 25^{1.2.9}-д “зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нормын хувцас, хэрэгсэл, сургалт, дадлагын зардлыг санхүүжүүлэх” гэсэн заалт нэмснийг УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн чуулганаар хэлэлцэж хүчингүй болгосон нь сангийн хөрөнгийг урсгал зардалд зарцуулах нөхцлийг зогсоосон байна.

1.4 Сургалтын төрийн сан

Эрх зүйн зохицуулалтыг бүрэн бүрдүүлээгүй байна

УИХ-аас 2011 онд баталсан “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай” хуулийн дагуу ЗГ-ын 2012 оны 19 дүгээр тогтоолоор “Сургалтын төрийн сангийн дүрэм”, “Сургалтын төрийн сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн”, “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”, “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам” болон “МУ-д эрэлт ихтэй мэргэжлийн жагсаалт” зэрэг дүрэм, журмыг баримтлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөн Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын тэтгэлэг олгох журам”, Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн чиглэл”-ийг тус тус шинэчлэн, Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-д холбогдох өөрчлөлтийг хийж “Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 3, 5 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсон байна.

Өөрөөр хэлбэл 2011 оноос хойшхи хугацаанд “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай” МУ-ын Ерөнхийлөгчийн 2013 оны 78 дугаар зарлиг, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор СТС-гийн бодлого, үйл ажиллагаанд өөрчлөлт, шинэчлэлт хийх

²¹ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4.2 дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө

²² 25^{1.2.8}-энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхэд оролцогч цэргийн албан хаагч амь насаа алдсан тохиолдолд цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу түүний ар гэрт нэг удаагийн тэтгэмжийг олгох.

²³ 25^{1.2.9}-зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нормын хувцас, хэрэгсэл, сургалт, дадлагын зардлыг санхүүжүүлэх.

Засгийн газрын тогтоол гарах бүрт СТС-гийн үйл ажиллагаанд нэмэлт, өөрчлөлт орж байжээ.

Аудит хийгдэх хугацаанд Сургалтын төрийн сан нь УИХ-ын 2016 оны “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-д өөрчлөлт оруулах тухай хууль болон Боловсролын зээлийн сан байгуулах талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2016 оны 111 дүгээр тогтоолоор “Боловсролын зээлийн сан” болж өөрчлөн зохион байгуулагдсан байна.

БҮЛЭГ.2 САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬД ЗААСАН ЭХ ҮҮСВЭР БҮРЭЭР БҮРДҮҮЛЭХГҮЙ БАЙНА

2.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг төлөвлөхдөө тухайн жилийн элсэлтийн квот²⁴, өмнөх оны дэвшин суралцагсдын тоонд үндэслэн МБСБ-ын суралцагчдад олгох тэтгэлэг, хувьсах зардал гэсэн 2 төрлийн зардлыг санхүүжих дундаж хүүхдээр тооцох аргачлал ашиглан төлөвлөж байна.


Хувьсах зардлын төлөвлөлтийг сурагчдын дундаж тоог нэг хүүхдэд ногдох тухайн газар нутагт тогтоогдсон нормативт хэмжээгээр 2015 онд 12,334 суралцагчаар тооцоолж нийт 6,919.9 сая төгрөгөөр тусгасан ба энэ зардлыг 15 хувиар бууруулан 5,861.7 сая төгрөгөөр, 2016 онд 15,324 суралцагчаар тооцож 6,829.9 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Харин тэтгэлэгийн зардлыг төрийн болон хувийн өмчит сургуулиудын нийт суралцагчдын дундаж тоог сар тутам олгох 70.0 мянган төгрөгөөр тооцож 2015 онд 37,529 суралцагчдад 9 сарын хугацаанд олгохоор төлөвлөж хэмнэлт үүсэх магадлалаар²⁵ нь 5 хувь бууруулан 22,798.4 сая төгрөг, 2016 онд 40,348 суралцагчаар тооцож 70.0 мянган төгрөгийг 10 сарын хугацаанд өгөхөөс хэмнэлт үүсэх магадлалаар нь 70 хувиар тооцож 19,770.0 сая төгрөгийн тэтгэлэг олгохоор төлөвлөсөн байна.

Сангийн хөрөнгийг 2015 онд 28,860.1 сая төгрөгөөр төлөвлөж батлуулснаас төсвийн тодотголоор 23,899.1 сая төгрөг, гүйцэтгэлээр 15,094.8 сая төгрөг, санхүүжилтгүйн улмаас тэтгэлэг болон хувьсах зардлын 8,368.4 сая төгрөгийн өглөг үүсгэсэн ба 2016 онд 26,599.9 сая төгрөгөөр төлөвлөж батлуулснаас төсвийн тодотголоор 15,094.8 сая төгрөг, эхний хагас жилийн гүйцэтгэлээр 14,919.7 сая төгрөгийн зарцуулалт хийгдэж, 5,896.4 сая төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8²⁶-д заасныг зөрчих нөхцөл болж байна.

МБСДС-ын хөрөнгийн төлөвлөлт, гүйцэтгэлийг он тус бүрээр харуулбал:

/сая төгрөгөөр/



²⁴ “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэн зохион байгуулах бөгөөд эрэлтийн судалгааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана”, Засгийн газрын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан тэтгэлэг олгох журмын 2 дахь хэсгийн 2.1.2-т “жил бүрийн элсэлтийн хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, орон нутгийн захиалгад үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан байх”

²⁵ 24-өөс дээш насны болон ирц 75 хувьд хүрэхгүй суралцагч байх магадлалаар

²⁶ “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”

ЛЖич: 2016 оны гүйцэтгэлд өмнөх онд үүссэн өглөг орж байна/

2016 оны 9 дүгээр сард МУ-ын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэг хүүхдэд ногдох хувьсах зардал, тэтгэлгийн зардлаас 2016-2017 оны хичээлийн жилийн 9-12 дугаар сарын зардалд төлөвлөж байсан 17,971.2 сая төгрөгийг хассан байна.

Хуулиар тодорхойлсон эх үүсвэр бүрээр хөрөнгийг бүрдүүлээгүй байна

МБСДС-ийн орлогыг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1²⁷ -д заасан 6 эх үүсвэрээс, мөн Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2 дахь хэсгийн 2.1²⁸ -д заасан эх үүсвэрээс тус тус бүрдүүлэхээр хуульчилсан ба 2015 онд улсын төсвөөс 15,965.5 сая төгрөг, ОУБ-ын хандив, тусламжаар 68.1 сая төгрөг, 2016 онд улсын төсвөөс 15,154.3 сая төгрөг, ОУБ-ын хандив, тусламжаар 35.6 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Аудитад хамрагдсан хугацаанд Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, 22.1.3, 22.1.5, 22.1.6-д заасан эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлээгүй байна.

2.2 Байгаль хамгаалах сан

Сангийн хөрөнгийн 2015, 2016 оны төлөвлөлт, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/				
Он	Төсвийн төсөл	Батлагдсан	Тодотгол	Гүйцэтгэл
2015	5,445.3	2,678.2	2,086.6	1,776.4
2016 оны 8 дугаар сарын байдлаар	2,614.7	1,900.0	1,896.0	889.9

Сангийн төлөвлөлтийг батлагдсан төсөвтэй харьцуулбал 2015 онд 2.7 тэрбум төгрөг буюу 50.8 хувь, 2016 онд 0.7 тэрбум төгрөгөөр буурсан нь улс орны эдийн засгийн байдал хүндэрсэнтэй холбоотой бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1²⁹-д заасан зарчмыг баримтлаагүй байна.

Тус сангийн нэмэлт санхүүжилтын дансаар УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан БОНХАЖЯ, СЯ болон НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн

²⁷ 22.1.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

22.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.2.орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.3.гадаад улс, олон улсын байгууллагаас мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих зорилгоор олгосон зээлийн хөрөнгө, буцалтгүй тусламж;

22.1.4.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж;

22.1.5.аж ахуйн нэгж, байгууллагаас энэ хуулийн 20.3-т заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө;

22.1.6.бусад эх үүсвэр.

²⁸ сангийн хөрөнгө нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 20.3 , 22.1-т заасан эх үүсвэр болон ЗГ-ын захиалгат төсөл, хөтөлбөрөөс бүрдэнэ

²⁹ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

хооронд 2015 оны 2 дугаар сард байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлж буй “Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл, Сургуулийн ногоон барилга, тогтвортой худалдан авалтын ажил” төслийн хүрээнд 2015 онд 579.8 сая төгрөгийн санхүүжилт орж 554.3 сая төгрөгийн зарлага, 2016 онд 201.8 сая төгрөгийн санхүүжилт орж 8 дугаар сарын байдлаар 32.3 сая төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулсан байна.

Сангийн хөрөнгийг ЗГТСТ хуульд заасан төрөл тус бүрээр бүрдүүлээгүй байна

БХС нь 2015 онд 3 төрлийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхээс зөвхөн ЗГТСТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1³⁰-д заасан 89.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Мөн УИХ-аас 2015 онд ЗГТСТ хуульд нэмэлт өөрчлөлт оруулж 2016 оноос 6 төрлийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх болсноос 8 дугаар сарын байдлаар тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын дагуу 108.1 сая төгрөг, 12.1.4³¹ дэх заалтын дагуу 2,000.0 сая төгрөг нийт 2,108.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Дээрх хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасан орлого, мөн 12.1.3³²-д заасан орлого нь “Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ, тогтоох тухай” журмыг ЗГ-аас батлаагүйгээс орлого төвлөрөөгүй байна.

Харин энэ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5³³, 12.1.6³⁴ дахь заалтын хүрээнд одоогоор орлого бүрдээгүй бөгөөд хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар БХС-ийн удирдлага ажиллаагүй байна.

Орон нутгийн БХС Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д заасан орлогыг ЗГТСТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т заасны дагуу ЗГ-ын БХС-д төвлөрүүлэлгүй орон нутгийн БХС-д төвлөрүүлсэн байна. Тухайлбал:

- Говьсүмбэр аймаг 2015-2016 онд ЗГ-ийн БХС-д төвлөрүүлбэл зохих нөхөн төлбөрийн 8.3 сая төгрөгийн орлогыг БОАЖГ-ын үйл ажиллагааны дансанд төвлөрүүлсэн;
- Сэлэнгэ аймаг ЗГ-ын БХС-д төвлөрүүлбэл зохих орлогоос 2015 онд аймгийн БХС-д 4.3 сая төгрөг, Жавхлант сумын БХС-д 1.0 сая төгрөг, Мандал сумын БХС-д 6.8 сая төгрөг, Хүдэр сумын БХС-д 7.5 сая төгрөг, Хушаат сумын БХС-д 0.4 сая төгрөг, 2016 оны эхний 8 сард аймгийн БХС-д 11.8 сая төгрөг, Мандал сумын БХС-д 18.1 сая төгрөг, Хүдэр сумын БХС-д 24.6 сая төгрөг тус тус төвлөрүүлэн зарцуулсан байна.

Үүний улмаас ЗГ-ын БХС-д төвлөрүүлэх 82.8 сая төгрөгийн орлого буурч, орон нутагт төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах эрсдэл үүсгэж ЗГТСТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг зөрчсөн байна.

³⁰ Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж

³¹ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого

³² Ус бохирдуулсны төлбөрийн орлого

³³ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрмжийг борлуулсны орлого

³⁴ Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлого

Цаашид Төсвийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2³⁵, 18.5³⁶ дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 4-3/760 тоот аймаг, нийслэлийн засаг дарга нарт хүргүүлсэн зөвлөмжийг баримтлан орон нутгийн БХС-ийн орлого бүрдүүлэх, зарцуулах журмыг аймгийн ИТХ болон ЗД боловсруулан баталж эрх зүйн зохицуулалтыг хангах шаардлагатай байна.

2.3 Зэвсэгт хүчний хөгжлийн сан

Сангийн орлогыг 2015 онд ЗГТСТ хуулийн 25¹ дугаар зүйлийн 25^{1.1}-д заасан 5 эх үүсвэрээс нийт 42,749.1 сая төгрөг, 2016 онд 47,172.2 сая төгрөг тус тус төлөвлөсөн байна.

Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлогын төлөвлөгөөг эх үүсвэрийн ангиллаар харуулбал:

Эх үүсвэр	Орлогын төлөвлөгөө			
	2015 он		2016 он	
	Дүн	Хувь	Дүн	Хувь
Оны эхний үлдэгдэл	14,608.5	34.2%	19,031.6	40.3%
НҮБ-ын энхийг дэмжих ажиллагааны нөхөн төлбөрийн орлого	8,192.1	19.2%	9,816.4	20.8%
Гадаад улс, олон улсын байгууллагын болон бусад буцалтгүй тусламж, хандив	-	-	-	-
НҮБ-ын энхийг дэмжих ажиллагаанд МУ-ын зэвсэгт хүчнээс ашиглуулсан зэвсэглэл, техник хэрэгсэл, материалын нөхөн төлбөрийн орлого	19,250.4	45.0%	17,626.1	37.4%
Энхийг дэмжих ажиллагааны хамтарсан сургууль, дадлагын нөхөн төлбөр	428.0	1.0%	428.0	0.9%
Улсын хэмжээний бүтээн байгуулалтад цэргийн анги салбарыг оролцуулснаас олсон ашиг	200.0	0.5%	200.0	0.4%
Зэвсэглэлээс хасагдаж акт тавигдсан зарим төрлийн техникийг худалдан борлуулсаны орлого	70.0	0.2%	70.0	0.1%
ДҮН	42,749.1	100.0%	47,172.2	100.0%

2015 онд орлогын бүрдүүлэлт 49,498.7 сая төгрөг төвлөрсөн боловч Сангийн яам 30,467.1 сая төгрөгийг санд хуваарилж санхүүжилтын эрх нээгээгүй 19,031.6 сая төгрөгийг он дамжуулан олгосон ба 2016 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 35,836.9 сая төгрөг төвлөрч 11,836.4 сая төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байгаа нь СЯ-аас санхүүжилтын эрх нээгээгүйтэй холбоотой байна.

2.4 Сургалтын төрийн сан

Сангийн хөрөнгийг хуулиар тодорхойлсон эх үүсвэр тус бүрээр бүрдүүлээгүй байна

СТС нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-аар тодорхойлсон “эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг улсын төсвөөс бүрдүүлэх

³⁵ Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан, орон нутгийн тусгай сан гэсэн төрөлтэй байна

³⁶ Засгийн газрын тусгай сан нь улсын төсвийн, орон нутгийн тусгай сан нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна

сан"-д хамаарах бөгөөд хуулийн 7 дугаар зүйлийн 7.1³⁷-д заасан нийтлэг эх үүсвэрээс гадна хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 "сургалтын зориулалттай зээлийн төлбөр", 16.1.2 "буцалтгүй тусламжийг давхардуулан олгосон зөрчлийг арилгахтай холбогдсон болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр"-ээс бүрдэх эрх зүйн зохицуулалттай байна.

2015-2016 оны сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлтийг хүснэгтээр үзүүлбэл:

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2015 ОН		2016 ОН	
		Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
1	Улсын төсвийн санхүүжилт	81.523.4	59.249.2	54.679.0	32.960.0
2	Ханлив	0.00	0.00	0.00	0.00
3	Зээл	0.00	0.00	0.00	0.00

Дээрхээс үзэхэд СТС нь 100 хувь төсвийн санхүүжилтээр бүрдсэн байна.

2015, 2016 онуудад ЗГТСТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасан "сургалтын зориулалттай зээлийн төлбөр"-т төлөгдсөн зээл байхгүй бөгөөд 1997-2010 онд 53 суралцагч 416.1 мянган ам.долларын зээлийг эргүүлэн төлсөн бол 2011-2014 онд 2 суралцагч 33.5 мянган ам.долларыг төлжээ.

ЗГТСТ хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.2-т заасан эх үүсвэрээс хөрөнгө төвлөрүүлэхгүй байгаа нь өмнөх бүлэгт дурдсан "Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль"-ийн 8 дугаар зүйлийн 8.8³⁸-д заасан журмыг БСШУЯ УИХ-д өргөн барьж батлуулаагүйтэй нэг талаар холбоотой байна.

Мөн Улсын төсвийн санхүүжилтээс гадна 2015, 2016 оны эхний хагас жилд бусад эх үүсвэрээс бүрдэх хөрөнгийг төвлөрүүлэх талаар сангийн удирдлага санаачилга гарган ажиллаагүйгээс хуулийн дээрх заалтыг ханган биелүүлээгүй байна.

³⁷ а."улсын төсвийн хөрөнгө", б."гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив", в."гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл"

³⁸ Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно.

БҮЛЭГ.3 САНГИЙН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА

3.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Аудит хамрах хугацаанд МБСДС Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын 3.1.1-д заасан зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- 2015 онд суралцагчдын тэтгэлэгт 11,251.3 сая төгрөг, хувьсах зардалд 4,488.8 сая төгрөг;
- 2016 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны тэтгэлэгийн өглөгт 6,875.6 сая төгрөг, 1,2 дугаар сарын тэтгэлэгт 3,273.7 сая төгрөг, нийт 10,149.3 сая төгрөг, хувьсах зардалд 4,696.6 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Мөн МБСБ-уудын удирдлагын мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэх “Сургалт удирдлагын систем нэвтрүүлэх тухай” Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/190 дугаар тушаалыг 2015, 2016 онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлж нийт 267.5 сая төгрөгийг 15 аймаг дахь МБСБ, Хөдөлмөрийн яамны албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн зардалд зарцуулан “Карьер март” ХХК болон “Ай Си Ти Вишн” ХХК-уудаар гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБӨҮХӨТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2³⁹ дахь заалтыг зөрчсөн байна.

Сангийн хөрөнгөөр тэтгэлэг, хувьсах зардлыг журмын дагуу санхүүжүүлж байгаа ч зарим зөрчил гарч байна

Сангаас санхүүжүүлсэн хувьсах зардал, амьжиргааны тэтгэлгийг холбогдох хууль, журмын⁴⁰ дагуу олгож байгаа боловч хууль, журамтай нийцэхгүй дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- 2016 оны эхний 6 сарын байдлаар 3-6 дугаар сарын тэтгэлгийг суралцагчдын дансанд шилжүүлээгүй нь ЗГ-ын 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ын 3.3⁴¹ дахь заалтыг хэрэгжүүлээгүй;
- ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ын 2 дугаар хэсгийн 2.2 “Тэтгэлгийг мэргэжлийн боловсролыг анх удаа эзэмшиж байгаа суралцагчдад олгоно” гэсэн заалтыг Архангай аймгийн Гурван тамир МСҮТ-д 5, Дэд бүтэц МСҮТ-д 3, Булган МСҮТ-д 3, Архангай МСҮТ-д 6, Баянхонгор аймгийн политехник коллежид 13, Говь-Алтай аймгийн АШУИС-ийн салбар сургуульд 3, Өлзийт ХАА-н МСҮТ-д 71 суралцагч жил дараалан, 1 суралцагч 3 жил дараалан суралцаж тэтгэлэг авсан;
- Мөн журмын 1⁴² 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан журмын 1.2⁴³-т заасныг зөрчиж Булган аймаг дахь ХАА-н МСҮТ 0.3 сая төгрөг, Булган аймаг дахь МСҮТ 1.3 сая төгрөг, Говь-Алтай аймаг дахь АШУИС-ийн салбар сургууль 1.6 сая төгрөг, Дархан-Уул аймаг дахь МСҮТ 0.5 сая төгрөг,

³⁹ Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.

⁴⁰ “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль”, “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”

⁴¹ “Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.2-т заасан мэдээллийг хянан магадласны үндсэн дээр тэтгэлгийг суралцагчдын дансанд сар бүр шилжүүлнэ”

⁴² Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн сургалт эрхэлдэг байгууллага (Цаашид “сургууль” гэх)-д мэргэжлийн анхан, дунд шатны сургалтаар мэргэжил эзэмших 24 хүртэлх насны суралцагчдад тэтгэлэг олгоход энэхүү журмыг баримтална.

⁴³ Сургалтын байгууллагын мэргэжлийн боловсролын 1 болон 2,5 жил, техникийн боловсролын 1,5 болон 3 жилийн сургалтад хамрагдаж байгаа 24 хүртэлх насны суралцагчдад тэтгэлэг олгоно.

Дархан-Өргөө политехник коллеж 1 сая төгрөг, ХААИС-УГТХ-ийн дэргэдэх МСҮТ 0.07 сая төгрөг, УУЭХ-ний политехник коллеж 0.7 сая төгрөг, Дорнод аймгийн политехник коллеж 1.7 сая төгрөг, Төв аймаг дахь МСҮТ 0.8 сая төгрөг, Заамар сумын МСҮТ 0.2 сая төгрөг, Баянчандмань сумын МСҮТ 1.7 сая төгрөг, Эрдэнэ сумын МСҮТ 0.7 сая төгрөг, нийт 9.1 сая төгрөгийн тэтгэлэг илүү олгосон;

- ЗГ-ын 2007 оны 294 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 4-т “Суралцагч хичээлдээ суугаагүй хугацаанд тэтгэлэг олгохгүй” гэснийг зөрчиж Архангай аймгийн Булган МСҮТ, Дэд бүтэц МСҮТ нь 2015, 2016 оны 2 дугаар сард сурагчдын амралтын хугацаанд 8.0 сая төгрөг, Дархан-Өргөө политехник коллеж 0.4 сая төгрөг, Дорнод аймгийн МСҮТ 0.3 сая төгрөг нийт 8.7 сая төгрөгийн тэтгэлэг олгосон;

- 2015 оны 477 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2 дахь хэсгийн 2.2.2-т “Хүндэтгэн үзэх шалгаантайгаас (эрүүл мэндийн болон ар гэрийн гачигдал гэх мэт) бусад тохиолдолд онолын болон дадлагын сургалтад 75 хувиас доошгүй ирцтэй оролцсон байх” гэж заасныг зөрчиж Говь-Алтай аймаг дахь АШУИС-ийн салбар сургууль 0.7 сая төгрөг, Дорнод аймгийн политехник коллеж 0.4 сая төгрөг, Орхон МСҮТ 0.4 сая төгрөг, Орхон ХАА-н МСҮТ 0.9 сая төг, Завхан аймгийн политехник коллеж 3.2 сая төгрөг, нийт 5.6 сая төгрөг олгосон;

- Хөдөлмөрийн яамнаас Өмнөговь аймгийн политехник коллежид 1.4 сая төгрөг, Улаанбаатар хотын Дон Боско МСҮТ-д 3.3 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон, Баянхонгор аймгийн Өлзийт хөдөө аж ахуйн МСҮТ хичээлийн ирцийн зөрүүнээс 3.4 сая төгрөгийг сурагчдад олгоогүй буюу санд буцаан төвлөрүүлээгүй нийт 8.1 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон;

Мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн ажил эрхлэлт хангалтгүй байна

ХЯ-ны МБСЗГ-аас 2015 онд явуулсан судалгаагаар 18,978 суралцагч төгссөний 10,759 буюу 56.7 хувь нь ажлын байртай болсон байна⁴⁴. Тухайлбал:

- Архангай аймагт нийт төгсөгчдийн 41 хувь;
- Баян-Өлгий аймагт нийт төгсөгчдийн 28.5 хувь;
- Баянхонгор аймагт нийт төгсөгчдийн 62.3 хувь;
- Говь-Алтай аймгийн МСҮТ төгсөгчдийн 56 хувь, АШУИС-ын салбар сургуулийг төгсөгчдийн 88 хувь;
- Завхан аймгийн политехник коллежийн төгсөгчдийн 66 хувь, МСҮТ төгсөгчдийн 49 хувь;
- Орхон аймгийн нийт төгсөгчдийн 50 орчим хувь;
- Ховд аймгийн нийт төгсөгчдийн 70.5 хувь;
- Хөвсгөл аймгийн нийт төгсөгчдийн 63.3 хувь нь тус тус ажлын байртай болсон байна.

Дээрхээс үзэхэд төгсөгчдийн ажлын байраар хангагдах байдал хангалтгүй байгаа тул МБСБ-ууд төрөөс санхүүжилт авахын тулд хүүхдийн тооны араас хөөцөлдөхгүй байхад анхаарч, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, ажил олгогчийн захиалга, сургалтын чанар зэргийг сайжруулах шаардлагатай байна.

3.2 Байгаль хамгаалах сан

Зөвшөөрөлгүй ангилал шилжүүлэн гадаад томилолт санхүүжүүлжээ

“БХС-ийн зардлын задаргаа батлах, эрх шилжүүлэх тухай” БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-34 дүгээр тушаалаар сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 33 төсөл, арга хэмжээг 2.7 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1.8 тэрбум төгрөг, “БХС-ийн зардлын задаргаа батлах, эрх шилжүүлэх тухай” 2016 оны А-10 дугаар тушаалаар 1.9 тэрбум төгрөг баталж 8 дугаар сарын байдлаар 0.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

⁴⁴ Эх сурвалж - ХЯ-ны статистик мэдээ

Аудитад хамрагдсан хугацаанд батлагдсан төсвийг хэмнэсэн боловч төлөвлөгөөнд туссан 2 чиглэлийн хөтөлбөр, арга хэмжээг 29.0 сая төгрөгөөр хэтрүүлэн санхүүжүүлсэн байна. Үүнд:

- БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/347 дугаар хөрөнгө гаргах тухай тушаалаар Хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлаарх Монгол, Оросын засгийн газар хоорондын комиссын 5 дугаар хуралдааныг зохион байгуулахдаа батлагдсан төсвийг 17.4 сая төгрөгөөр;
- 2016 оны А/193 дугаар тушаалаар Увс нуурын хотгор хил дамнасан дархан газрын Монгол Оросын 3 дугаар хурлыг Тува улсад зохион байгуулахад 11.6 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна.

Мөн сангийн төсөвт 2015, 2016 онуудад гадаад томилолтын зардал батлагдаагүй боловч бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлын ангиллаас 2015 онд 96.4 сая төгрөг, 2016 оны 9 дүгээр сарын байдлаар 114.3 сая төгрөг буюу нийт 210.7 сая төгрөгийг гадаад томилолтод олгосон нь ЗГТСТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.2⁴⁵, 32 дугаар зүйлийн 32.1⁴⁶, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5⁴⁷, мөн *"БХС-ийн зардлаар хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх журам"*-ын 6⁴⁸ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл хөтөлбөрийг хууль, журмын дагуу сонгон шалгаруулаагүй байна

БХС сангийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтгүйгээр гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 33 дугаар зүйлийн 33.2.1⁴⁹, 47 дугаар зүйлийн 47.1⁵⁰ дэх заалтыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- 2015 оны А/187 дугаар тушаалаар Идэр голын сав газрын захиргаанд Эко танхим байгуулах 30 сая төгрөгийн төсөл;
- А/310 дугаар тушаалаар Мөнхөд үржих хайрхан ХХК нь Завхан аймгийн Завхан мандал суманд Усжуулалтын систем байгуулах 35 сая төгрөгийн төсөл;
- БОНХАЖС-ын А/112 дугаар тушаалд үндэслэн ТНБД-ын 2016 оны А/213 дугаар тушаалаар *"Сорог төгөл"* ХХК нь Чулуут нуурын баян бүрдийг хаших 46.2 сая төгрөгийн төсөл.

Мөн БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-179 дүгээр тушаалаар байгуулагдсан *"БХС-ийн захирлын дэргэдэх төсөл сонгон шалгаруулах зөвлөл"* нь 10 сая төгрөгийн төсөвт өртөг давсан төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулалтгүйгээр санхүүжүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 33 дугаар зүйлийн 33.2.1 дэх заалтыг баримтлаагүй байна. Тухайлбал:

- БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/200 дугаар төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай тушаалаар *"Байгальд ээлтэй хөгжил"* ТББ-тай 24.9 сая төгрөг, *"Хангайн нурууны байгалийн цогцолборт*

⁴⁵ Энэ хуулийн 12.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

⁴⁶ Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

⁴⁷ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁴⁸ Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

⁴⁹ Техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хангаж байгаа 3 болон түүнээс дээш этгээдэд үнийн санал ирүүлэхийг мэдэгдэх.

⁵⁰ Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.

газрын хамгаалалтын захиргаа"-тай 12.9 сая төгрөг, "Ногоон тэмүүлэл, тогтвортой хөгжил" НҮТББ-тай 30.0 сая төгрөгийн төслийг сонгон шалгаруулалтгүйгээр гэрээ байгуулсан байна.

Орон нутгийн БХС-аас санхүүжүүлсэн 2 төсөл, хөтөлбөрийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2.1 дэх заалтыг баримталж сонгон шалгаруулаагүй байна. Үүнд:

- Дундговь аймгийн Гурвансайхан сумын орон нутгийн байгаль хамгаалах сангаас 16.0 сая төгрөгийн өртөг бүхий хогийн цэгийн хог шуух ажил, 37.9 сая төгрөгийн өртөг бүхий ногоон байгууламжийн хамгаалалтын хашаа, гүн өрмийн худгийн барилгын ажлыг шууд гэрээгээр;

- Сэлэнгэ аймгийн Хүдэр сум нь 2015 онд орон нутгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр Тарвагатай 1 дүгээр баг, Баянцагааны 2 дугаар багт ногоон байгууламж, цэнгэлдэх хүрээлэн байгуулж тохижуулах 23.6 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг "Ургамал дөрөө" ХХК-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй байна

БХС-ийн дүрмийн 5.5-д *"Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж, шаардлагатай бол мэргэжлийн байгууллага хүмүүсээс зөвлөгөө авах, хөндлөнгийн үнэлгээ дүгнэлт гаргуулах ..."* гэж заасан байхад гэрээний хугацаа дууссан, гэрээнд заагдсан ажил үйлчилгээг хэрэгжүүлж дуусаагүй төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал:

- БОНХАЖ-ын сайдын 2016 оны А/134 дүгээр тушаалаар Эх байгаль, эрүүл хүнс судлалын хүрээлэн нь 8 сая төгрөгийн төсөвтэй "Байгаль орчны чанар, төлөв байдлын хяналт шинжилгээний сүлжээг боловсронгуй болгох санал боловсруулах" ажлыг гүйцэтгэхээр урьдчилгаа 4.0 сая төгрөгийг авсан боловч гэрээг дүгнэж, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулаагүй;

- БХС-ийн захирлын 18 дугаар тушаалаар Үндэсний цэцэрлэгт хүрээлэн НӨҮГ нь 9.5 сая төгрөгийн төсөвтэй ногоон дэвтэр хөтөлбөрт гэрээний урьдчилгаа 4.7 сая төгрөгийг авсан боловч гэрээг дүгнэж ажлын гүйцэтгэлийг баталгаажуулаагүй;

- БХС-ийн захирлын 29 дүгээр тушаалаар "Өлзийт бор тал хоршоо" ТББ нь 9.5 сая төгрөгийн төсөвтэй Завхан аймгийн Яруу суманд Атаршиж хаягдсан газрыг нөхөн сэргээх төслийн урьдчилгаа 4.7 сая төгрөг, "Таанат Тэс" ТББ нь 9.5 сая төгрөгийн төсөвтэй Завхан аймгийн Тэс суманд Цөлжилттэй тэмцэж Ойн зурвас байгуулах төслийн урьдчилгаа 4.7 сая төгрөгийг авсан боловч гэрээг дүгнэж ажлын гүйцэтгэлийг баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчлүүдээс үзэхэд гэрээлэгч талууд хамтран ажиллах гэрээний 6.1⁵¹-д заасан хүлээх хариуцлагын дагуу арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Орон нутгийн БХС-ийн хөрөнгөөр гэрээ байгуулалгүй төслийн ажлыг санхүүжүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2⁵² дахь заалтыг баримтлаагүй байна. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд 2015 онд 4.7 сая төгрөгийн өртөг бүхий ойжуулалт, ойн цэвэрлэгээний ажлыг сумын Ойн ангиар гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй бөгөөд гүйцэтгэлийг комиссын актаар баталгаажуулаагүй байна.

Орон нутгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрөөс зорилтот үр дүндээ хүрээгүй ажил байна

⁵¹ Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.5 хувийн алданги төлнө

⁵² ... заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана

Орон нутгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь зорилтот үр дүндээ хүрээгүй байна. Тухайлбал:

- Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт 8.0 сая төгрөгөөр 4 га талбайд “Ойн зурвас байгуулах” ажлыг гүйцэтгүүлэхээр “Онгон-Арвижих” ОНӨААТҮГ-тай 2015 оны ОЗБ-2015/01 дүгээр гэрээ, Баяндэлгэр сумын нутагт 4.0 сая төгрөгөөр 2 га талбайд “Ойн зурвас байгуулах” ажлыг гүйцэтгүүлэхээр “Талын жимс” ТББ-тай 2015 оны ОЗБ-2015/01 дүгээр гэрээ тус тус байгуулан санхүүжилтийг бүрэн олгосон боловч ургалт хангалтгүй, суулгацын амьдралт зохих түвшинд хүрээгүй;

- Завхан аймгийн Дөрвөлжин сумын Засаг дарга сангийн хөрөнгөөр 2016 онд 19.0 сая төгрөгөөр цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх газрын генератор худалдан авахаар гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаа 2016 оны 7 дугаар сарын 30-нд дууссан байхад уг гэрээг дүгнээгүй;

БХС болон орон нутгийн байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6⁵³-д заасны дагуу хяналт хийж төсөл хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэх шаардлагатай байна.

3.3 Зэвсэгт хүчний хөгжлийн сан

ТБОНӨХБАҮХАТ хуулийг хэрэгжүүлэхгүй байна

Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний урилгыг e-procurement.mn вэб хуудсанд байршуулж үр дүнг мэдээлсэн эсэхийг хянахад 2015 онд 10, 2016 онд 2, нийт 12 төсөл, арга хэмжээний урилга байршуулж, бусад төсөл, арга хэмжээний урилгыг байршуулаагүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.4⁵⁴, 2016 онд нийт 9 төсөл, арга хэмжээ, 2015 онд нэг ч тендер шалгаруулалтын үр дүнг мэдээлээгүй байгаа нь дээрх хуулийн 52 дугаар зүйлийн 52.1.12⁵⁵ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу зохион байгуулаагүй байна

БХЯ-ны ТНБД-ын 2015 оны А/13, А/29, А/32, А/47, А/58, А/64 дүгээр тушаалаар нийт 6 үнэлгээний хороо байгуулахдаа үнэлгээний хорооны гишүүдийг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байдлаар бус албан тушаалаар заасан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.6⁵⁶, Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаалаар батлагдсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2⁵⁷ дахь заалтыг зөрчсөн байна.

Мөн БХАҮН ТӨҮГ-ын худалдан авах ажиллагааны үнэлгээний хороо 2016 онд Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 6 нээлттэй тендер зарласан боловч тендерийн бичиг баримт бэлдээгүй, тендерт оролцогчидод зөвхөн ажлын ерөнхий хэмжээ өгсөн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн

⁵³ Захиалагч нь бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих

⁵⁴ 21.4.Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ.

⁵⁵ 52.1.12.худалдан авах ажиллагааны мэдээ, мэдээлэл, тендер шалгаруулалтын зар, үр дүнг нийтэд түгээх зорилготой вэб хуудас хөтлөх, түүнд тендерийн урилга, бусад мэдээлэл тавих арга, хэлбэрийг тогтоох;

⁵⁶ 47.6. Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

⁵⁷ 2.2. Хуулийн 47.6-д заасны дагуу Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх бөгөөд 47.4-д заасан төлөөллийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд заавал оруулна.

47.2.1⁵⁸ дэх заалт, Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоодын төлөөлөл, иргэдийн төлөөлөгч оролцуулаагүй нь 47 дугаар зүйлийн 47.4⁵⁹ дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Түүнчлэн Үнэлгээний хороо тендерийг үнэлсэн дүгнэлтээ албан ёсоор БХЯ-нд хүргүүлдэггүй нь хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.2⁶⁰ дахь заалтыг зөрчсөн байна.

Батлан хамгаалах яам 2015 онд 821.8 сая төгрөгийн 5 тендерт, 2016 онд 200.0 сая төгрөгийн 1 тендерт барилга угсралтын тусгай зөвшөөрөлгүй компани шалгаруулж, гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1⁶¹ дэх заалтыг зөрчсөн байна, эдгээр ажлуудыг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Төсөл, арга хэмжээний нэр	ХАА-г зохион байгуулсан газар	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Гүйцэтгэгчийн нэр
2015 он				
ЗХ-ний 016 дугаар ангийн 200 цэргийн байрны засвар	ЗХЖШ	588.0	484.0	Брайт пэинт ХХК
ЗХ-ний 016 дугаар ангийн 200 цэргийн байрны гал тогооны дээвэр засвар	ЗХЖШ		104.0	
Өгөөмөр-1 нэгдсэн агуулах	ЗХЖШ	164.3	164.3	Баустандарт ХХК
Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн хувцасны агуулахын дээврийн засвар	ЗХЖШ	29.0	29.0	Томуж ХХК
Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн нэгдсэн агуулахын дээврийн засвар	ЗХЖШ	40.4	40.4	
2015 оны дүн		821.8	821.8	
Дуулга студийн засвар	БХАҮН ТӨҮГ	200.0	200.0	Сытый папа ХХК
2016 оны дүн		200.0	200.0	
НИЙТ ДҮН 2015, 2016 он		1,021.8	1,021.8	

Зэвсэгт хүчний ангиуд гэрээгээр хүлээсэн үүргээ бусдад шилжүүлжээ

Зэвсэгт хүчний анги салбаруудад барилга байгууламж барих, барилгын болон сантехник, дээврийн засвар хийх зэрэг ажлуудыг ЗХЖШ-ын даргын 2015 оны А/129, А/328, 2016 оны А/57, А/69, А/125, А/291 дүгээр тушаалуудаар барилгын цэргийн 017, 338, 339, 340 дүгээр ангиудаар гүйцэтгүүлэхээр баталж, зөвлөмжийг БХЯ-ны БЗА-нд хүргүүлж, гэрээ байгуулсан байна.

⁵⁸ 47.2.1.техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, тендерийн баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, тендер нээх ажиллагааг холбогдох зааврын дагуу гүйцэтгэх;

⁵⁹ 47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

⁶⁰ 47.2.2.тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх. Уг шийдвэрийг энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан үндэслэлгүйгээр өөрчлөхийг хориглоно

⁶¹ 27.1.1 Энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхийн шаардлага

Барилгын цэргийн дээрх ангиуд нь гэрээний үүргээ туслан гүйцэтгэгчид шилжүүлэн ажлын 50-100 хувийг гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2⁶² дахь заалтыг зөрчсөн байна. (Хавсралт №1-д үзүүлэв.)

Мөн Батлан хамгаалах сайдын 2014 оны А/19, 2015 оны А/57, А/209, 2016 оны А/105, А/158, А/160, А/168 дугаар тушаалаар ЗХХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 13 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын захиалагчаар БХАҮН ТӨҮГ-г томилж эрх шилжүүлсэн байна.

БХАҮН ТӨҮГ барилга угсралтын ажлын тусгай зөвшөөрөлтэй боловч, эрх шилжүүлсэн ажлуудыг гүйцэтгэх тоног төрөөрөмж, техник хэрэгсэл, боловсон хүчингүй учир дахин сонгон шалгаруулалт явуулж, шалгарсан компанийн үнийн санал, төсөвт өртгийн зөрүүгээр ашиг олж, өөрийн байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлэн ажиллаж байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁶³-д заасан үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтлаагүй байна.

БХАҮН ТӨҮГ-т эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааны судалгааг он тус бүрээр хавсралт №2-т үзүүлэв.

БХЯ худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй нь хавсралтад үзүүлсэн 268.2 сая төгрөг хэмнэж бусад шаардлагатай төсөл, арга хэмжээнд зарцуулах боломж алдсаныг аудитын явцад тогтоолоо.

Сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим төсөл, арга хэмжээ зорилтот үр дүндээ хүрээгүй байна

Сангийн хуулийн үзэл баримтлалд ЗХХС-г Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, зэвсэглэл, техникийг үе шаттайгаар шинэчлэх, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадавхи, боломжийг нэмэгдүүлэх, сургалт бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох, батлан хамгаалахын салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах зорилготой гэж тодорхойлсон байна.

ЗХХС-ийн 2015, 2016 оны хөрөнгө оруулалтаар дээрх үзэл баримтлалын зорилготой нийцүүлэн хэрэгжүүлсэн боловч төслийн нэр, утга агуулгатай нийцэхгүй 4 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн нь ЗГТСТ хуулийн 25¹ дугаар зүйлийн 25.2.1-25.2.9 дэх заалтыг зөрчсөн байна. Үүнд:

/сая төгрөгөөр/

Төсөл, арга хэмжээний нэр	ХАА-г зохион байгуулсан газар	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гүйцэтгэгч компанийн нэр
2015 он				
БХЯ, ЗХЖШ-ын гадна Асфальтан зам шинэчлэх	ЗХЖШ	300.0	110.0	Хөвсгөл барилга ХХК, БСМ ХХК
БХЯ, ЗХЖШ-ын гадна зам талбай, хашааны шинэчлэл	ЗХЖШ		190.0	Зэвсэгт хүчний 017 дугаар анги
2015 оны дүн		300.0	300.0	

⁶² 41.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

⁶³ 6.1. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

2016 он				
БХЯ-ны үүдний зааланд тавигдах дэлгэц	БНХАУ ЭСЯ	4.5	4.5	БНХАУ ЭСЯ-нд суугаа атташе
БХЯ-ны бялдаржуулах өрөөг тохижуулах	ЗХЖШ	35.0	35.0	Солид Констракшн ХХК
2016 оны дүн		39.5	39.4	

Батлан хамгаалах сайдын 2015 оны А/262 тоот тушаалаар ЗХ-ний 017, 338, 339, 340 дүгээр ангиудыг цэргийн албан хаагчдын 300 айлын дутуу гүйцэтгэсэн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч талын хүлээлгэн өгсөн материалыг түшиглэн үргэлжлүүлэн дуусгах, барилгыг ашиглалтанд оруулах шаардлагатай материалын зардлыг тооцож, ЗХХС-гаас 1,151.7 сая төгрөг санхүүжүүлснийг гүйцэтгэгч компаниар нөхөн төлүүлэхээр хуулийн байгууллагад хандсан байна.

Мөн ЗХХС-ийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтын баримт материалаар хавтаст хэрэг бүрдүүлж ажиллаагүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1⁶⁴ дэх заалтыг биелүүлээгүй байна.

3.4 Сургалтын төрийн сан

Сангийн хөрөнгийг гадаад, дотоодын ДБСБ-д суралцагчдын тэтгэлэгт зарцуулжээ

СТС нь 2015-2016 онд дотоод, гадаадын ДБСБ-ын 85.9 мянган суралцагчдад 87.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулснаас 69.3-80.6 хувь буюу 63.6 тэрбум төгрөгийг тэтгэлэг тусламжид, 30.7-19.39 хувь буюу 23.8 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгожээ. Үүнд:

Ангилал	2015			2016		
	Оюутны тоо	Дүн /сая төгрөг/	Хувь	Оюутны тоо	Дүн/сая төгрөг/	Хувь
СТС-ийн зээл (дотоод)	1985	1,499.9	2.5	1728	567.7	2.0
СТС-ийн зээл (гадаад)	308	16,679.0	28.1	154	4761.6	17.3
Зээлийн дүн		18,178.9	30.6		5425.2	19.3
Оюутны тэтгэлэг	51721	21,356.9	36.0	41950	13873.6	49.5
Урамшууллын тэтгэлэг	9621	4,489.2	7.5	0	0	0.0
ТАХ-ын 1 хүүхдийн	2685	1,504.7	2.5	533	203.4	0.7
Сургалтын төлбөрийн	5273	7,137.7	12.0	5415	5686.2	20.3
Замын зардал	13962	1,404.6	2.3	11674	1085.9	3.8
ЗГГ-ээр гадаадаас дотоодод	229	333.0	0.5	122	287.3	1.0
Суралцагчдад олгох	106	1,145.9	1.9	0	0	0.0
Гадаадад бакалаврт	34	3,691.3	6.2	0	0	0.0
Багш мэргэжлээр өндөр	0	0.0	0.0	1504	1223.9	0.0
Орон нутагт багшлах	0	0.0	0.0	367	186.5	0.0
Буцалтгүй тусламжийн дүн		41,063.3	69.3	61,565.0	22546.8	80.6
Нийт дүн		59,242.2			29,233	

⁶⁴ 49.1.Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.

2015 онд нийт санхүүжилтын 30.7 хувийг эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлд, 69.3 хувийг тэтгэлэг тусламжид, 2016 оны эхний хагас жилд нийт санхүүжилтын 19.4 хувийг эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл, 80.6 хувийг тэтгэлэг, тусламжийн зардалд зарцуулсан бөгөөд үндэсний тэтгэлгийг эс тооцвол дийлэнх хэсгийг эргэн төлөгдөх зээлийн санхүүжилтэд зарцуулсан нь санг улсын төсвөөс хараат бус бие даасан байлгах, түүний хөрөнгийг нөхөн бүрдүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

СТС-аас 2015 он, 2016 оны эхний хагас жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийг хүснэгтээр үзүүлбэл:

		2015	2016	Нийт
Дотоодын ДБСБ-д	Суралцагсад /давхардсан тоогоор/	1985	1839	3824
	Олгосон нийт зардал /сая.төг/	1,499.9	567.7	2067.6
Гадаадын ДБСБ-ын магистрантур,	Суралцагсад /давхардсан тоогоор/	160	77	237
	Олгосон нийт зардал /мян ам.дол/	3,100.0	1831.52	4931.5
	Олгосон нийт зардал /сая.төг/	6,050.8	2289.4	8340.2
ДШИС-ийн бакалаврт	Суралцагсад /давхардсан тоогоор/	147	77	224
	Олгосон нийт зардал /мян ам.дол/	5,400.0	1210.7	1750.7
	Олгосон нийт зардал /сая.төг/	10,635.2	2472.2	13107.4
Нийт	Суралцагсад /давхардсан тоогоор/	2292	1993	4285
	Олгосон нийт зардал /мян ам.дол/	8,500.0	3042.2	11542.2
	Олгосон нийт зардал /сая төгрөг/	18,185.9	5329.3	23515.2

Гадаадын ДБСБ-д 1997-2015 онд СТС-ийн зээл, тусламжаар суралцагчдын гэрээний хэрэгжилтийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

Үзүүлэлт	2011-2015 он		
	Суралцагчдын тоо	Нийт зардал (сая төгрөг)	Хувь
Төгсөөд ажиллаж байгаа	152	4,489.6	17.9
Төгсөөд ажил эрхлээгүй	30	1,107.9	3.5
Төгсч чадаагүй	2	40.0	0.2
Зээл төлсөн	2	33.5	0.2
Төгссөн боловч бүртгүүлээгүй	115	3,142.1	13.5
Үргэлжлүүлэн суралцаж байгаа	478	18,437.1	56.2
Хоёр улсын Засгийн газар болон хамтарсан сангуудын тэтгэлэг	72	2,379.9	8.5
НИЙТ	851	29,630.1	100.

Дээрхээс үзэхэд нийт зээлдэгчийн 17.9 хувь нь төгсөөд эргэн ирж ажиллаж байгаа нь “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-д заасан “...нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэсэн байх” зорилтыг хангахгүй байна.

Мөн ЗГ-ын 2014 оны 71 дүгээр тогтоолоор “ДШИС-д оюутан суралцуулах тухай” журамд орсон өөрчлөлтийг⁶⁵ СТС бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

⁶⁵ Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”-д дараах өөрчлөлтийг оруулсугай: 2.1. журмын 2.3 дахь хэсгийг “Сургалтын зээл нь сургалтын төлбөр

• СТС-аас 2014-2015 онд бакалаврын 14 суралцагчид сургалтын төлбөр дээр амьжиргааны зардал болон бусад зардлын нийт 283.1 мянган ам.долларыг илүү олгосон нь ЗГ-ын 2014 оны 71 дүгээр тогтоолын дээрх заалттай нийцэхгүй байна.

Сургалтын талаарх мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна

СТС нь ЗГ-ын 2012 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “ДБСБ суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зээл олгох журам”-ын 1.5-д “... хяналтын тооны хуваарийг холбогдох байгууллага, олон нийтэд мэдээлэх ажлыг хариуцна” гэж заасныг баримтлан гадаадын ДБСБ-д СТС-ийн зээлээр суралцуулах хяналтын тоог цахим хуудсаар мэдээлээгүй, ЗГ-ын 2013 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “ДШИС-д оюутан суралцуулах журам”-ын 1.8-д “... Суралцагчдын нэр, сургууль, мэргэжлийн чиглэлийн талаарх мэдээллийг Сургалтын төрийн сангийн цахим хуудсанд байршуулна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Барьцааны гэрээ байгуулахдаа хөрөнгийн үнэлгээ хийлгэх шаардлагатай байна

СТС-аас зээл олгох журам⁶⁶-д заасны дагуу 2012 оноос эхлэн суралцагчтай Зээлийн гэрээ байгуулахдаа улсын бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн Үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ авах болсноор гадаадын ДБСБ-д СТС-ийн зардлаар 1997-2010 онд суралцаж төгсөөгүй болон төгсөөд бүртгүүлээгүй суралцагч нийт суралцагчдын 28.1 хувийг эзэлж байсан бол 2011-2015 онд энэ үзүүлэлт 13.7 хувь болж буурчээ.

Харин барьцаа хөрөнгийн үнэ сургалтын зардалтай харьцуулахад хэт доогуур байгаа тул үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хийлгэх, олгож буй зээлийн дүнд дүйцсэн хөрөнгө барьцаалах шаардлагатай байна.

байна.” гэж өөрчлөх; 2.2.журмын 2.6 дахь хэсгийн “..., амьжиргааны зардлыг суралцагчийн дансанд тус тус” гэснийг хасах.

⁶⁶ Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт 3.2.“Сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээлийг магистрантад 2 жил, докторантад 3 жил хүртэлх хугацаатайгаар үл хөдлөх хөрөнгө барьцаалан олгоно”, Засгийн газрын 2013 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 2.4.“Сургалтын зээлийг тухайн их сургуулиас ирүүлсэн нэхэмжлэлийг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгө барьцаалан олгоно”

БҮЛЭГ.4 ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

4.1 Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан

ХЯ сургалт удирдлагын нэгдсэн систем нэвтрүүлэхээр 2014 оноос хойш төрийн өмчийн 42 сургууль буюу нийт МСҮТ-ийн 53 хувийг мэдээллийн нэгдсэн системд хамруулсан нь МБСТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.12⁶⁷-т заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Цаашид мэргэжлийн боловсрол, сургалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, төр хувийн хэвшлийн сургалтын байгууллагад суралцагчдын хичээлийн ирц, тэтгэлэгт хамрагдах боломжийг хянах, хяналтын нэгдсэн системтэй болох шаардлагатай байна.

ХЯ-ны ХШҮДАГ-ын 2014 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтээр мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хэрэгжилтийг 78.9 хувиар дүгнэсэн бөгөөд 2015 оны үйл ажиллагаанд дотоод хяналт хийхдээ зөвхөн төрийн өмчит МБСБ-ыг түүвэрчлэн 13 МСҮТ-ийг хамруулсан нь хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо цөөн, хувийн өмчийн МСҮТ, политехник, коллежуудад хяналт хийгээгүй байгаа тул цаашид хяналт, шалгалтыг тогтмол явуулах, хууль журмаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Шилэн дансны мэдээллийг ил тод нээлттэйгээр мэдээлсэн байна

МБСДС-ийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2016 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар www.shilendans.gov.mn сайтаар орж үзэхэд шаардлагатай мэдээллийг мэдээлсэн байна.

Аудитын явцад ирүүлсэн албан бичигт дурьдсан асуудлын хүрээнд:

Аудитын хугацаанд МУИС-ийн Бизнесийн сургуулийн дэргэдэх МСҮТ-ийн 2016 оны 8д/429 дугаар албан бичигт дурдсан асуудлыг аудитын хүрээнд шалгалаа.

Мэргэжлийн боловсролын салбарт ажиллаж байгаа багш нарын нийгмийн баталгааг Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1⁶⁸, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3⁶⁹-т тодорхойлсон

⁶⁷ мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи статистик болон бусад мэдээллийн нэгдсэн тогтолцоо, сан бүрдүүлэх, хөтлөх;

⁶⁸ 43.1. Багш нийгмийн дараахь баталгаагаар хангагдана:

43.1.2.багш, ажиллагчдын ээлжийн үндсэн амралтын хугацааг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулна. Хөдөлмөрийн онцлогийг харгалзан багшид ажлын 33, захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, хичээлийн зохицуулагч, нийгмийн ажилтан, арга зүйч, дадлагын болон байрны багш, цэцэрлэгийн туслах багшид ажлын 15 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно. Хөдөлмөрийн тухай хуулийн 79.5, 79.6-д заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан бусад нэмэгдэл амралт дээрх албан тушаалтанд хамаарахгүй;

43.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход түүний үндсэн цалингаар тооцож нэг удаагийн буцалтгүй мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгах;

⁶⁹ 19.3.Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно.

боловч төрийн өмчийн их дээд сургуулийн дэргэдэх тодотголтой МБСБ-ууд нь аль сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах нь тодорхойгүйгээс төрийн өмчийн хэлбэрээр байгуулагдаж байсан дээрх сургуулийн багш нарын нийгмийн баталгаагаар хангагдах асуудал орхигдсон байна.

Иймээс дээрх сургуулиудын харьяалах яам, санхүүжилтын эх үүсвэрийг тодорхой болгож багш нарын нийгмийн баталгаагаар хангах асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байна.

Аудитаар өгсөн акт, албан шаардлагын дүн:

МБСДС-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын явцад 599.4 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлснээс 48.6 сая төгрөгийн 22 акт тогтоож, 283.2 сая төгрөгийн 14 зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага, 267.5 сая төгрөгийн зөрчилд аудитын зөвлөмж өгч ажиллалаа. Үүний 256.6 сая төгрөгийн зөрчил нь НББ-ийн алдаа болон шилэн дансны мэдээлэлтэй холбоотой, 26.6 сая төгрөгийн зөрчил нь тэтгэлэгтэй холбоотой албан шаардлага байна.

4.2 Байгаль хамгаалах сан

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁷⁰, ЗГТСТ хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1⁷¹-д заасны дагуу дотоод хяналт, шалгалтын тогтолцоо БХС-д бүрдсэн боловч 2015, 2016 онуудад БОНХАЖ-ын яамны ХШҮДАГ-аас ЗГ-ын БХС-д хяналт тавьж ажиллаагүй байна.

Орон нутгийн байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд хийж буй аудитаар дотоод хяналтыг *"5 аймаг хангалттай, 2 аймаг хангалтгүй, 4 аймаг огт хэрэгжүүлээгүй байна"* гэж дүгнэгдсэн байна.

Шилэн дансны тухай хуульд заасны дагуу сумдууд хангалтгүй мэдээлж байна

ЗГ-ын БХС нь шилэн дансны тухай хуулийн хүрээнд мэдээллээ байршуулж байгаа боловч сумдын орон нутгийн байгаль хамгаалах сангийн хувьд хангалтгүй мэдээлж хуулийг бүрэн хэрэгжүүлэхгүй зөрчил гарсан байна. Тухайлбал:

- Говьсүмбэр аймгийн Шивээговь, Баянтал сумдууд орон нутгийн байгаль хамгаалах сангийн нэгдсэн шилэн данс цэсэнд байршуулаагүй;
- Дорноговь аймгийн Иххэт, Айраг, Мандах, Хатанбулаг, Сайншанд, Хөвсгөл сумдууд шилэн дансны нэгдсэн системд орон нутгийн байгаль хамгаалах сангийн орлого, зарлагыг мэдээлээгүй;
- Завхан аймгийн Дөрвөлжин сумын ЗДТГ-аас цаг агаарт зориудаар нөлөөлж хур тундас нэмэгдүүлэх газрын генератор худалдан авахаар хөрөнгө зарцуулсан мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй;
- Орон нутгийн байгаль хамгаалах сангийн 2015 оны орлого, зарлагын мэдээллийг Сэлэнгэ аймгийн Түшиг сумаас бусад сум, 2016 оны эхний 8 сарын байдлаар орлого, зарлагын мэдээллийг Хүдэр сум тус тус мэдээлээгүй байна.

⁷⁰ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.

⁷¹ Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ.

4.3 Зэвсэгт хүчний хөгжлийн сан

ХШУДАГ ЗХХС-ийн зарцуулалтад хяналт хийгээгүй байна

БХЯ-ны ХШУДАГ Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалт хийгээгүй нь холбогдох хууль, журмыг биелүүлээгүй, сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, хөрөнгө оруулалтын үр дүн, үр өгөөжийг тооцохгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

ЗХХС-ийн зарцуулалтын мэдээллийг 2016 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар хянаж үзэхэд зэвсэгт хүчний барилгын цэргийн ангиудын хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээллийг бүрэн оруулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үүргийг биелүүлээгүй байна.

4.4 Сургалтын төрийн сан

БСШУЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас СТС-ий үйл ажиллагаанд 2015-2016 онуудад хяналт шинжилгээ хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3⁷²-т заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Сангийн Удирдах зөвлөл болон БСШУЯ-ны ХШУДАГ-аас тус сангийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

СТС нь төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгааныг мэдээлэхдээ зөвхөн мөнгөн дүнгээр илэрхийлж тэдгээрийн шалтгааны тайлбарыг мэдээлээгүй байна.

⁷² Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.

ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн нотлох зүйлсэд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Эрх зүйн орчныг бүрдүүлэхээр баталсан хууль, журмын заалтууд нь бусад хууль тогтоомжтой нийцэхгүй, тодорхойгүй, шаардлагатай журам, зааврыг батлаагүй байгаагаас шалтгаалан сангийн үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадахгүй байна.
- ЗГТС-ууд нь хуулиар тодорхойлсон эх үүсвэр тус бүрээр хөрөнгө бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Сангийн хөрөнгийг ТБОНӨХБАҮХАТ хууль болон холбогдох журмыг зөрчин зориулалтын бус төсөл арга хэмжээнд зарцуулсан байна.
- Аудитад хамрагдсан ЗГТС-уудад сангийн Удирдах зөвлөл болон тухайн асуудал эрхэлсэн яамны ХШҮДАГ-аас үр дүнтэй хяналт зохион байгуулаагүй байна.
- ЗГТС-ууд нь Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Монгол Улсын Засгийн газарт:

1. Аудитын тайланд дурдагдсан тусгай сангийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, батлагдаагүй журам, зааврыг батлах;
2. ЗГТС-уудад улсын төсвөөс бусад эх үүсвэрээс төвлөрүүлэх хөрөнгийг нэмэгдүүлэх;
3. Аудитын тайланд тусгагдсан хууль, журмыг зөрчиж сангийн хөрөнгийг зарцуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох;
4. Яамдын ХШҮДАГ-аас хэрэгжүүлэх дотоод аудитыг тогтмол үр дүнтэй зохион байгуулах.

Хавсралт № 1

Барилгын цэргийн ангиуд гуравдагч этгээдэд шилжүүлсэн төсөл, арга хэмжээ

Барилгын цэргийн ангиудын нэр		Үндсэн гэрээний дүн	Үүнээс туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн гэрээний дүн	Төсөл, арга хэмжээний тоо	/сая төгрөгөөр/ Үүнээс туслан гүйцэтгэгчээр хийлгэсэн ажлын:	
					гэрээний тоо	Үндсэн гэрээнд эзлэх хувь
2015 он	Зэвсэгт хүчний 017 дугаар анги	4,918.60	1,707.67	25	22	88.0%
	Зэвсэгт хүчний 338 дугаар анги	3,500.14	973.16	17	15	88.2%
	Зэвсэгт хүчний 339 дугаар анги	1,582.30	1,207.25	2	1	50.0%
	Зэвсэгт хүчний 340 дүгээр анги	2,365.59	250.00	6	1	16.7%
	Нийт дүн	12,366.63	4,138.08	50	39	78.0%
2016 он	Зэвсэгт хүчний 017 дугаар анги	1,920.26	1,285.45	26	15	57.7%
	Зэвсэгт хүчний 338 дугаар анги	910.66	443.08	3	3	48.7%
	Зэвсэгт хүчний 339 дугаар анги	-	-	-	-	-
	Зэвсэгт хүчний 340 дугаар анги	652.96	-	1	0	0%
	Нийт дүн	3,483.88	1,728.53	30	18	60.0%

Хавсралт №2

БХАҮН-д эрх шилжүүлсэн төсөл арга, хэмжээ

/сая төгрөгөөр/

2015 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ						
1	Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид цахилгааны эх үүсвэрийн шинэчлэлтийн ажил	2014 A/19	1,235.2	1,235.2	-	Нартай констракшн ХХК
2	Зэвсэгт хүчний 311 дүгээр ангид спорт бэлтгэлжилтийн төвийн барилгын ажил		1,624.1	1,624.1	-	Нартай констракшн ХХК
3	"Ахлагч хотхон"төслийн гадна цэвэр усны огтолгоо,халаалтын тогооны барилгын ажил	2014 A/57	250.0	249.9	0.1	Мэрмэйд ХХК, Ноён цамхаг, Ди Эл Ти ХХК, Уранванчин ХХК
4	Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн байрлалд баригдах "Цэрэг орд хотхоны" орон сууцны барилга	2015.07.17 A/209	960.0	960.0	-	Классик дизайн ХХК, Түшиг багана ХХК, Солонго цамхаг ХХК
5	ЗХЖШ 1 дүгээр шатны эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх	2015.07.17 A/209	102.4	100.9	1.5	Марос ХХК
6	ЗХЖШ 2 дугаар шатны эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх	2015.07.17 A/209	408.9	408.9	-	БХАҮН ТӨҮГ
7	Шумуулын хамгаалалттай хээрийн хувцасны материал нийлүүлэх	2015.07.17 A/209	190.0	190.0	-	БХАҮН ТӨҮГ
	Дүн 2015 он		4,770.6	4,769.0	1.5	
2016 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ						
1	"Дуулга студийн" шинэчлэл	2016.06.06. A/168	196.0	176.0	20.0	Сытый папа ХХК
2	Энхийг дэмжих ажиллагааны хүлээн авалтын өрөө тохижуулах ажил	2016.06.06. A/168	300.0	268.0	32.0	Натур Өргөө ХХК
3	Зэвсэгт хүчний 336 анги 200 цэргийн байрны засвар	2016.05.27 .A/158	1,164.5	1,006.4	158.1	ХБО ХХК
4	БХИС-ийн барилга байгууламжийн дээврийн засвар	2016.05.27. A/160	173.4	166.2	7.2	Амина шилтгээн ХХК
5	БХИС-ийн хичээлийн 1-р байрны засварын ажил	2016.05.27 .A/160	116.0	116.0	-	Баяндөрвөлж ХХК
6	Эмнэлгийн хэрэгсэл,эм нийлүүлэх гэрээ	2016.04.05 A/105	221.9	172.5	49.4	Би Эйч Эм Эс ХХК
	ДҮН 2016 он		2,171.8	1,905.1	266.7	
	Нийт дүн /2015. 2016/		6,942	6,674	268.2	

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, нийслэлийн дүүрэг,
Нэгдсэн үндэсний гудамж 5, 7-ас: 25-15-53
Факс: 32-86-34 Цахим хуудал: mha@mt.mongol.net
Цахим хуудал: mha.gov.mn

2016.11.09 № 10104

танай -ны № -т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗАРТ**

"Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн аудитын тайланд тусгайлан өгөх саналгүй болно.

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.МӨНХЗУЛ

**БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
ЯАМНЫ БОЛОВСРОЛЫН
ЗЭЭЛИЙН САН**

14191 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө 10, Багшийн
хөгжлийн ордон. Утас: 7010 9186, Факс: (976) 7010 4364,
E-mail: elf@mecss.gov.mn, http://www.elf.mn

2016.11.09 № 533

танай -ны № -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Тайлбар хүргэх тухай

Нийцлийн аудитаас гаргасан тайланд өгөх дүгнэлтэнд тусгайлан санал байхгүй болно. "Сургалтын төрийн сан" нь Засгийн Газрын 111-р тогтоолоор "Боловсролын зээлийн сан" болж өөрчлөгдсөн тул тус тайланд өгсөн зөвлөмжийг цаашдаа үйл ажиллагаандаа тусган ажиллах болно.

ЗАХИРАЛ

1116130487
УХА0599 5053145

П.ЛХАГВАСҮРЭН

**МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ**

13340 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 51, Засгийн газрын VII байр,
Утас: 26 35 31, Факс: (976-11) 45 81 12,
E-mail: info@mod.gov.mn, http://www.mod.gov.mn

2016.11.08 № 673588

танай 2016.11.04-ны № 81504-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН НИЙЦЛИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА БАЛТАНЗУЛ
ТАНАА**

Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн 2015-2016 оны үйл ажиллагаа, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад санал, тайлбараа хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХУРАНДАА

Б.БАТСАЙХАН

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Амарын гудамж, 22-р байр, 7 тоот
Утас: (976-11) 310753, Факс: (976-11) 310748
И-мэйл: contact@ncl.mn, http://www.ncl.mn

2016.11.09 № 128

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Хариу албан бичиг
хүргүүлэх тухай

Танай байгууллагын 2016 оны 11 дүгээр сарын 04-ны өдрийн 2/1503 тоот "Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Байгаль хамгаалах сангаас аудитын ирүүлсэн тайлангийн төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.

ЗАХИРАЛ

Х.ГАНБААТАР



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2016 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 9/120

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайлан, аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хороо, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 5 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар /Ж.Мөнхбат/-т зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

071187

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 1.1 дугаар сарын 26-ны өдрийн 1/1 дугаар тушаалын хавсралт

УХА0122

“Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Засгийн газрын тусгай сангийн нэр	Байгууллагын нэр	Төлбөр, зөрчил хариуцагчийн		Төлбөр, зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Актын дугаар	Төлбөр, зөрчлийн дүн /төгрөг/
			Нэр	Албан тушаал				
1	Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан	Дон боско МСҮТ	Leung Kon Chiu Krzysztof Wladyslaw	Захирал СА-ны дарга	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн.		2016.11.16 1/34	3,339,338
2	Байгаль хамгаалах сан	Байгаль хамгаалах сан	Х.Ганбаатар	Захирал	ТӨНӨХБӨҮХАТ хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 33 дугаар зүйлийн 33.2.1, ЗГТСТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 32 дугаар зүйлийн 32.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт болон Байгаль хамгаалах сангийн дүрэм, гэрээлэгч талуудын хамтран ажиллах гэрээг зөрчсөн.	2016.11.16 11/151		485,200,000
3	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	Батлан хамгаалах яам	Б.Батсайхан	Төрийн нарийн бичгийн дарга	ТӨНӨХБӨҮХАТ хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, 41 дүгээр зүйлийн 41.2, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх дахь заалтуудыг зөрчсөн.	2016.11.16 8/150		6,888,398,100
Нийт дүн								
								7,376,937,438



Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Засгийн газрын зарим тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн Үндэсний аудитын газрын нийцлийн аудитын тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай:

1/улсын төсвийн нэгдмэл байдлыг хангах, тусгай сангуудын зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох, үр дүнг дээшлүүлэх, хоорондын уялдаа холбоог сайжруулах, давхардлыг арилгах, сангуудын зохицуулалтыг нэг хуулиар зохицуулах зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх;

2/тусгай сангийн үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй, санхүүгийн эх үүсвэрийг хуулиар тодорхойлсон заалт бүрээр бүрдүүлээгүй, сангийн хөрөнгийг хууль бусаар зарцуулсан албан тушаалтанд хариуцлага тооцох;

3/тусгай сангуудад үүссэн өр, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг улирал тутам тус Байнгын хороонд танилцуулах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо /З.Нарантуяа/, Монгол Улсын Ерөнхий аудитор /Д.Хүрэлбаатар/ нарт тус тус даалгасугай.

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ч.ХҮРЭЛБААТАР

ТЭМДЭГЛЭЛ

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

[illegible]